

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан 2022 оны 9 сарын 15-ны өдрийн 1/17 дугаар удирдамжийн дагуу Булган аймгийн Хутаг-Өндөр сумын “Илчит Хутаг” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгч зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч А.Анхбаяр 2022 оны 9 сарын 29-ний өдрөөс хуанлийн 7 хоногт багтаан хяналт шалгалтыг хийв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

“Илчит-Хутаг” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн гаргасан заавар, журам, дүрмийн хэрэгжилтийн байдал,

Үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөлт, түүний гүйцэтгэлийн байдал,

Харилцах дансны болон кассын орлого, зарлагын гүйлгээг үндсэн баримтууд, бараа материал, үнэт цаасны тайлан, хөрөнгийн бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн журналууд, дансны бичилтүүдтэй тулган шалгах,

Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцэл гаргалт, хөрөнгийн тооллого, тооцоо бодолт,

Байгууллага хоорондын тооцоо өглөг авлага, түүний баталгаажуулалт, бүртгэл тайланд тусгасан байдал,

Ажиллагсдын цалин хөлс, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн дагуу тогтоож, бодож олгосон байдал

Албан томилолтын зардлын тооцоо төлсөн байдал,

Шатахуун, сэлбэгийн тооцоо бодолтын байдал,

“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулав.

ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Хутаг-Өндөр сумын “Илчит Хутаг” ОНӨААТҮГ нь сумын ИТХ-ын 2014 оны 35 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна .

Хутаг-Өндөр сумын “Илчит Хутаг” ОНӨААТҮГ-ын зорилго нь төвлөрсөн дулааны шугамд холбогдсон ААН, байгууллага, айл өрхүүдэд дулааны эрчим хүчийг найдвартай, тасралтгүй дамжуулж, дулаанаар хангах зорилготой. Байгууллагын үндсэн чиг үүрэг нь дулаан үйлдвэрлэх, дулаан дамжуулах, дулаанаар хангахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг цэвэр бохир усан хангамжийг бий болгох, усыг түгээх, ашиглалт, засвар үйлчилгээг хангах, дулаан түгээх, дулаан зохицуулах, засварлах, дагалдах ажил болон сумын төвийн хуурай хог хаягдлыг стандартын хүрээнд зайлуулах, үйлдвэрийн газар нь үндсэн үйл ажиллагаанаас гадна хуулиар хориглоогүй бусад бизнесийн үйл ажиллагааг явуулж орлого ашгаа нэмэгдүүлэх гэж тодорхойлжээ.

Санхүүгийн үйл ажиллагааны 1 дүгээр гарын үсгийг 2021 оны 01 сарын 01-нээс 2021 оны 01 сарын 31-ний өдрийг хүртэл О.Далайцэрэн 2021 оны 2 сарын 03-наас 2021 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл Д.Шинэбаяр, 2 дугаар гарын үсгийг 2021 оны 01 сарын 01-нээс 2021 оны 4 сарын 13-ныг хүртэл Ж.Мөнхбаяр, 2021 оны 4 сарын 1-нөөс 2021 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл Т.Анхбаяр нар зурсан ба ХААН банкин дахь 5284174103 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэлийн тайланг санхүүгийн “STS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

Эд хариуцагчаар Б.Гантулга ажилласан байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Булган аймгийн Төрийн аудитын газраас хийсэн аудитын шалгалтаар хязгаарлалттай санал дүгнэлт авсан. Аудитаар нийт 200,824.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 83,353.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,461.3 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 25,762.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 90,247.1 төгрөгийн алдаа зөрчилд 6 зөвлөмж өгсөн байна.

ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

“Илчит Хутаг” ОНӨААТҮГ-ын 2021 оны касс харилцах, цалингийн баримт, захирлын тушаал, хүнс, бараа материалын баримт 2021 оны санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын баримт, хөдөлмөрийн дотоод журам, аудитын тайлан зэрэг баримт материалуудад тулгуурлан нягтлан бодогч Т.Анхбаяр, нярав Б.Гантулга нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийн талаар:

Хутаг-Өндөр сумын ИТХ-ын 2020 оны 2/09 дугаар тогтоолоор ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 580,877.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 552,965.4 мянган төгрөгөөр, 25,121.2 мянган төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Тайлант онд тус үйлдвэрийн газар нь 691,689.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 699,959.8 мянган төгрөгийн зардал гарган, 8,270.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна ба 2021 оны жилийн эцэст ХААН банкин дахь 5284174103 тоот дансны үлдэгдэл 24.283,9 мянган төгрөг, Төрийн банкин дахь 121600140869 тоот дансны үлдэгдэл 11,1 мянган төгрөг байна.

Зарцуулалт:

Иргэн Н.Галсанцэрэнтэй нэг нохойг 20,0 мянган төгрөгөөр үнэлэн золбин нохой устгуулахаар ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 3 сарын 5 өдөр нохой устгалын мөнгө 640,0 мянган төгрөгийг, 05 сарын 3-нд М.Намнансүрэнгийн ХААН банкны 5274226868 тоот дансанд золбин нохой устгалын мөнгө 640,0 мянган төгрөгийг, 3 сарын 30-ны Б/17 тоот тушаалаар “Илчит-Хутаг” ОНӨААТҮГ-ын 10 ажилтны шинжилгээнд хамрагдах мөнгөн төлбөр 200,0 мянган төгрөгийг 3 сарын 22-нд Д.Пүрэвдоржийн 5270392036 тоот дансанд, 3 сарын 25-нд үлдэгдэл 150,0 мянган төгрөгийг, Хутаг-Өндөр сумын хүн эмнэлгийн нэмэлт санхүүжилтийн 100041320401 тоот дансанд 7 сарын 5-ны өдөр 250,0 мянган төгрөгийг, 9 сарын 23-нд Зуухны тээврийн хөлс 2.000,0 мянган төгрөгийг, Зуух ачих томилолтын зардалд Д.Шинэбаярт 138,0 мянган төгрөгийг, ажилчдын хувцасны урьдчилгаа 2.574,0 мянган төгрөгийг 10 сарын 14-нд Ган-Үжингийн 5003894577 тоот дансанд, үлдэгдэл 1.961,0 мянган төгрөгийг 11 сарын 15-нд, ажилчдын гутлын үнэ 840,0 мянган төгрөгийг Дарханнэхий ХХК-ны Хаан банкин дахь 5045113201 тоот дансанд 10 сарын 13-нд, Л.Баярмагнайгийн ХААН банкны 5284016849 тоот дансанд 10 сарын 22-нд өвлийн гутлын үнэ 3.000,0 мянган төгрөгийг, “Илчит Хутаг” ОНӨААТҮГ нь иргэн Д.Эрдэнэдаваагаас 73-97 БУА улсын дугаартай Бонго маркийн тээврийн хэрэгслийг ИТХ-ын тогтоол, шийдвэргүйгээр худалдан авч, 4.700,0 мянган төгрөгийг 11 сарын 23-ны өдөр мөн өдөр 3.100,0 мянган төгрөгийг, 11 сарын 15-нд Гранд мед эмнэлгийн Хаан банкин дахь 5134035923 тоот дансанд 1.000,0 төгрөгийг ХААН банкны 5284053235 тоот дансанд, Шинэ жилийн баярын хүлээн авалтын зардалд 12 сарын 14-ний өдөр 1.585,0 мянган төгрөгийг Шар жолоо ХХК-ны Хаан банкин дахь 5286193656 тоот дансанд, шинэ жилийн бэлгэнд 647,2 мянган төгрөгийг, эмчилгээ сувилгааны зардалд 300,0 мянган төгрөгийг 12 сарын 31-ний өдөр Мон Эг ХХК-ны Хаан банкин дахь 5070033797 тоот дансанд тус тус шилжүүлсэн байна.

6.2. Цалин урамшууллын талаар:

Захирлын 1 сарын 4-ний өдрийн Б-21/2 тоот тушаалаар тогооч Л.Мөнхцэцэгийн сарын үндсэн цалинг 600,0 мянган төгрөгөөр, Б-21/3 дугаар тушаалаар машинист албан тушаалтай 8 ажилчны сарын үндсэн цалинг 650,0 мянган төгрөгөөр, Б-21/4 дугаар тушаалаар халуун усны ажилтан Л.Жаргалсайханы сарын үндсэн цалинг 600,0 мянган төгрөгөөр, Б-21/7 дугаар тушаалаар слесарь Б.Батболдын сарын үндсэн цалинг 750,0 мянган төгрөгөөр, Б-21/8 тоот тушаалаар цахилгаанчин З.Сэрээтэрийн сарын үндсэн цалинг 700,0 төгрөгөөр Б-21/9 тоот тушаалаар хүний нөөц П.Золзаяагийн сарын үндсэн цалинг 550,0 мянган төгрөгөөр, Б-21/10 тоот тушаалаар нярав Б.Гантулгын сарын үндсэн цалинг 650,0 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, Үйлдвэрийн газрын ажилчдын цалин хөлсөнд 172.803,8 мянган төгрөгийг, нийгмийн даатгалын шимтгэлд 53.122,0 мянган төгрөгийг, бараа материал худалдан авахад 128.216,6 мянган төгрөгийг, ашиглалтын зардалд 510,7 мянган төгрөгийг, татварт 66.922,749.128,8 мянган төгрөгийг, түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд 123.471,3 мянган төгрөгийг, бусад мөнгөн зарлагад 75.883,4 мянган төгрөгийг зарцуулсан байна. “Илчит Хутаг” ОНӨААТҮГ-ын захирлын 2021 оны 5 сарын 14-ний өдрийн Б/26 тоот тушаалаар 2020-2021 оны халаалтын улирал дуусаж байгаатай холбогдуулан тус үйлдвэрийн инженер, техникийн ажилчдад нэг удаагийн урамшууллыг 12 албан хаагчид 3.600,0 мянган төгрөгийг, 12 сарын 10-ны өдрийн 45/21 тоот тушаалаар ажлын үр дүнг үнэлж нэг удаагийн идэвхжүүлэлтийн урамшуулал 3.000,0 мянган төгрөгийн урамшууллыг

олгосон байна.

Захирлын 4 сарын 9-ний өдрийн Б/19 дугаар тушаалаар ачигч Ш.Гантогтох, слесарь Х.Мягмардорж, цэвэрлэх байгууламжийн техникч Э.Энхтүвшин нарт сануулах арга хэмжээ, 5 сарын 19-ний өдрийн Б/27 дугаар тушаалаар тус үйлдвэрийн газрын нярав Ж.Мөнхбаярт 3 сарын хугацаатай цалингийн 20%-иар сахилгын шийтгэл, 8 сарын 16-ны өдрийн Б/28 дугаар тушаалаар тус үйлдвэрийн газрын ус түгээгч Б.Одончимэгт 1 сарын хугацаатай цалингийн 20%-иар, мөн 8 сарын 16-ны өдрийн Б/29 дугаар тушаалаар тус үйлдвэрийн газрын ус түгээгч Х.Одонтунгалагт 1 сарын хугацаатай цалингийн 20%-иар сахилгын шийтгэл, 10 сарын 01-ний өдрийн Б/37 дугаар тушаалаар инженер Л.Дашжамц, цахилгаанчин З.Сэрээтэр нарт сахилгын сануулах арга хэмжээ, 10 сарын 01-ний өдрийн Б/38 дугаар тушаалаар машинист Х.Пүрэвнямд сахилгын сануулах шийтгэл, 11 сарын 03-ний өдрийн Б/41 дугаар тушаалаар механик Б.Батболд, машинист Б.Бат-Эрдэнэ нарт сахилгын сануулах шийтгэл, 11 сарын 03-ний өдрийн Б/42 дугаар тушаалаар инженер Л.Дашжамц нь өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй тул 1 сарын 20 хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэлийг тус тус ногдуулсан байна.

6.3. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

“Илчит хутаг” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 сарын 27-ны А/7 дугаар тушаалаар 12 сард үндсэн хөрөнгө, эд материалын тооллого хийх комиссыг 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан байна.

Үндсэн хөрөнгийн 2021 оны эхний үлдэгдэл 4.379.864,7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр 2.455,4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 4.680,0 мянган төгрөгийн программ хангамж, 7.800,0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг худалдан авч, 60.000,0 мянган төгрөгийн халаалтын зуух, 9.200,0 мянган төгрөгөөр винтлятор, 49.900,0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг үнэ төлбөргүй авч, ИТХ-ийн шийдвэрээр 6,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлан данс бүртгэлээс хасаж, хуримтлагдсан элэгдлийг 153.005,9 мянган төгрөгөөр тооцож, жилийн эцэст 3.987.616,6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

6.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /мянган төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Бэлэн бүтээгдэхүүн	1.393,7	9.218,5	9.745,5	866,7
2	Түүхий эд материал	2.180,8	44.069,8	37.531,7	8.718,8
3	Туслах материал	0,00	12.682,5	12.246,2	436,3
4	Хангамжийн материал	12.599,3	48.323,7	46.497,7	14.425,3
НИЙТ ДҮН		16.173,8	114.294,6	106.021,1	24.447,3

2021 оны эхэнд 16.173,8 мянган төгрөгийн бараа материал дээр 114.294,6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 106.021,1 мянган төгрөгийн бараа материал зарлагдаж оны эцэст 24.447,3 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

6.5. Өглөг, авлагын талаар:

Тайлант оны авлагын үлдэгдэлд дансны авлага 17,151.4 мянган төгрөг, НДШ-ийн авлага 183.5 мянган төгрөг, ажилчдаас авах авлага 2,578.3 мянган төгрөг, нийт 19.913,1 мянган төгрөгийн авлага байна.

Өглөгийн хувьд дансны өглөг 1.588,6 мянган төгрөг, НӨАТ-ын өглөг 24,2 мянган төгрөг, хүн амын орлогын албан татварын өглөг 610,6 мянган төгрөг, нийт 2.223,3

мянган төгрөг байна.

6.6. Шилэн дансны талаар: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд 2021 онд төсөв, гүйцэтгэл цэсэнд 49 мэдээлэл оруулахаас, 15 мэдээллийг хугацаа хоцроон, 1 мэдээллийг огт мэдээлээгүй, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын 39 мэдээллийг оруулахаас 23 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 16 мэдээллийг хугацаа хоцроон, бусад 61 мэдээлэл оруулахаас 41 мэдээллийг хугацаанд нь шивж, 20 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна. Төсөв гүйцэтгэл цэсэнд Санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлангийн дүгнэлтийг мэдээлсэн боловч хоосон мэдээлсэн, Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт /хагас, бүтэн жил сар, улирал бүр мэдээлэх мэдээллийг 4-р сард мэдээлээгүй, дараа жилийн төсвийн төсөөлөл мэдээлээгүй байна.

6.7. Бүцэлтгүй тусламжийн талаар

“Илчит-Хутаг” ОНӨААТҮГ-ын захирлын 2021 оны Захирлын 2021 оны 03 сарын 5-ны өдрийн Б/16 дугаар тушаалаар Хутаг-Өндөр сумын Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс 3-р сарын 7-нд “Ертөнцийн сайхан ээжүүд” арга хэмжээг зохион байгуулахад Л.Энхцэцэгийн 5043006450 тоот дансанд 500,0 мянган төгрөгийг, 9 сарын 30-ний өдрийн Б/35 дугаар тушаалаар тус үйлдвэрийн газрын ус түгээгч Ц.Ерсайханы хадам аав нас барсан тул дотоод журмын дагуу 300,0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг, 11 сарын 24-ний өдрийн Б/43 дугаар тушаалаар тус үйлдвэрийн газрын ачигч Ш.Гантогтохын гэр бүлд шинэ хүүхэд мэндэлсэн тул дотоод журамд заасны дагуу 100,0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг, 9 сарын 30-ний өдрийн Б/35 дугаар тушаалаар тус үйлдвэрийн газраас өндөр насны тэтгэвэрт гарсаг 4 ахмдад ахмадын баяраар хүндэтгэл үзүүлэхэд 200,0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

6.8. Албан томилолтын талаар:

Нягтлан бодогч Ж.Мөнхбаярт 2021 оны 02 сарын 22-ны өдөр тусгай зөвшөөрөл сунгуулах ажлаар Орхон, Булган аймагт ажилласан албан томилолтод, анхан шатны баримтгүйгээр 224,0 мянган төгрөгийг, 3 сарын 9-нд Ж.Мөнхбаярт албан томилолтын 280,0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүйгээр олгосон, Б.Гантулгад Булган аймагт тайлан тушаах ажлаар 3 сарын 17-ноос 2 хоног ажилласан албан томилолтын ирсэн явсан хугацааг бөглөөгүй, гарын үсэг тамга тэмдэггүй, очсон албан байгууллагын нэр байхгүй, зардлын гүйцэтгэлийн тооцоо хийлгүйгээр албан томилолтын зардал 112,0 мянган төгрөгийг Б.Гантулга, Л.Дашжамц, Б.Мөнхбаяр, Д.Мягмарсүрэн, Д.Шинэбаяр нар УБ хот руу сэлбэг хэрэгсэл худалдан авах ажлаар 6 сарын 7-ноос 5 хоног ажилласан албан томилолтын ирсэн явсан хугацааг бөглөөгүй, гарын үсэг тамга тэмдэггүй, очсон албан байгууллагын нэр байхгүй, зардлын гүйцэтгэлийн тооцоо хийлгүйгээр албан томилолтын зардал 345,0 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

6.9. Нүүрс тээвэрлэлтийн талаар:

2021 оны эхэнд нүүрсний үлдэгдэл 2.180,8 мянган төгрөгийн нүүрсний үлдэгдэл дээр 45.848,9 мянган төгрөгийн нүүрс худалдан авч, 39509,2 мянган төгрөгийн нүүрсийг зарлагдаж үлдэгдэл 8.520,4 мянган төгрөгийн нүүрс байна. Тайлант онд нүүрс тээврийн хөлсөнд 107.565,3 мянган төгрөгийг, түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд 15.905,9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**ДОЛОО. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН,
ЗӨРЧИГДСЭН ХУУЛЬ, ТОГТООМЖ**

1. Албан томилолтоор ажилласан албан хаагч нарт албан томилолтын зардлыг олгохдоо анхан шатны баримтын бүрдэл дутуу материалаар /томилолтын ирсэн, явсан хугацааг хаагаагүй, тамга гарын үсэггүй/ бодож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/ заасныг;

2. Агуулахын бүртгэл хөтлөөгүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг мөрдөж ажиллаагүй.

3. Чөлөө авсан ажилтны чөлөөний хуудсыг цагийн бүртгэлийн баримтад хавсаргаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/ заалтыг.

4. Дотоод хяналтын нэгж байгаа хэдий ч дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулаагүй, байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг хэрэгжүүлээгүй.

5. Нийгмийн даатгалын 2021 оны 3 сарын тайланд хүүхдээ асрах чөлөөтэй байгаа ажилтны цалинг хөдөлмөр хөлсний доод хэмжээ 420,0 мянган төгрөгөөс ажил олгогчийн төлөх 10,5 хувиар тооцон 2 удаа шивж тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасан /даатгуулагчийн шимтгэл төлөх тооцоог тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч, мөн зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн шимтгэл төлөх тооцоог нийгмийн даатгалын байгууллагын ажилтан гүйцэтгэнэ./ заалтыг,

6. Шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд 2021 онд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 51 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх зарчмыг баримтална/ заалт, 6 дугаар зүйлийн 6.1.2-т /.....сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор тогтмол мэдээлнэ./ заасан заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй;

НАЙМ. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар 2 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.

ЕС. ДҮГНЭЛТ

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй байгаа нь дотооддоо тавих хяналт сул, Шилэн дансны тухай хуулийн 4.1.3, 6.1.2, заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэлээ.

АРАВ. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

1. Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам албан бичгээр ирүүлэх.

2. Дотоод хяналт зохион байгуулах журам боловсруулан дотоод хяналтыг оновчтой төлөвлөж, дотоод хяналтын чанар үр нөлөөг дээшлүүлэн илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар холбогдох албан тушаалтан, ажилтанд хугацаатай үүрэг чиглэл өгч, биелэлтийг тооцон, удирдлагад танилцуулан хариуцлага тооцох санал хүргүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах.

3. Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын дагуу Санхүүгийн анхан шатны бүртгэлийн маягтыг бүрэн чанартай хөтлөх.

4. Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж, гүйцэтгэлийг хянан баримтжуулж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх.

5. Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулан 2022 оны 11 дугаар сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанд албан бичгээр болон sankhuu_audit_bu@yahoo.com хаягаар хариу ирүүлэх.

БИЧСЭН:

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ А.АНХБАЯР**

ХЯНАСАН:

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГА САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Б.БАТТУЛГА**